

Монгол улс, Улаанбаатар хот, СБ дүүрэг,
1-р хороо, Нарны зам, Юнион бүлдинг с-904
Утас:(976) 99198243, 99100082

Email: info@tgcaudit.mn

2023.04.21

№

23/52

таний

-ны №

-т

“МАНДАЛГОВЬ-ИМПЭКС” ХК -ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ө.БУДХАНД
ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Мандалговь-Импэкс” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөрх жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлтийн дэлгэрэнгүйгээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.
Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Мандалговь-Импэкс” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт болон Монгол улсын мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв, толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулиар шаардсан шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадна гэж үзлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв хийж санхүүгийн тайланг үнэн зөв тооцож гаргах нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмитай холбоотой асуудлыг тодруулах ба нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын

Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дах дун болон тодруулгын үндэслэлийг төстийн үндсэн дээр нягтлах, үнэн зөвийг батлах ажлыг багтаадаг.

Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш бөгөөд тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв бэлтгэхтэй холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоонууд, хэрэглэсэн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох “Мандалговь-Импэкс” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан тайлангууд болон тодруулга хүртэлх 4-23 хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

